



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/150

Арвайхээр

┌ Шуурхай штабын ажиллах журам, бүтэц, ┐  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “б”, 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 27.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” 22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Шуурхай штабын ажиллах журмыг нэгдүгээр, Шуурхай штабын бүтцийг хоёрдугаар, шуурхай штабын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үндсэн ажил, үүргийг зохицуулж, цалин хөлс, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт даалгасугай.

3.Шуурхай штабын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Шуурхай штаб (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/145 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100324

Аймгийн Засаг даргын 2021 оны.....  
дугаар сарын 19-ны өдрийн 4/150 дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал (цаашид “Цар тахал” гэх)-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах аймгийн Онцгой комиссын шуурхай штаб (цаашид “Шуурхай штаб” гэх)-ын үйл ажиллагааг зохицуулах, штабын ажилтан, багуудын эрх үүргийг тогтооход оршино.

1.1. Шуурхай штаб нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллана.

1.2. Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн Онцгой комиссын дарга батална.

### Хоёр. Шуурхай штабын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1. Аймгийн Онцгой комиссын дарга, Шуурхай штабыг Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийн дагуу удирдлагаар хангана

2.2. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг штабын дарга, түүний эзгүйд штабын орлогч удирдан зохион байгуулж, аймгийн Онцгой комиссын дарга бөгөөд аймгийн Засаг дарга хяналт тавина

2.3. Шуурхай штаб нь аймгийн Засаг даргын Тамгын газрын өргөтгөлийн байранд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд ажлын цагийн хуваарийг штабын дарга батална

2.4. Шуурхай штаб нь Улсын онцгой комиссын шийдвэртэй уялдуулж үйл ажиллагаагаа явуулна

2.5. Шуурхай штабын бүрэлдэхүүнд шийдвэр гаргах түвшний аймгийн Онцгой комиссын гишүүд ажиллана

2.6. Шуурхай штаб нь:

- Дарга
- Орлогч
- Нарийн бичгийн дарга

2.

- Хариу арга хэмжээний баг
- Удирдлага төлөвлөлт, хяналтын баг
- Санхүү хангалтын баг
- Мэдээлэл харилцаа холбоо-технологи, урьдчилсан сэргийлэх

багаас бүрдэнэ.



2.7.Хариу арга хэмжээг зохион байгуулах багт дараах үйл ажиллагаа хамаарна.

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналт
- Тусгаарлан ажиглалт
- Тархвар судлал, тандалт
- Хөдөлгөөний хязгаарлалт, хяналтын цэгийн үйл ажиллагаа

2.8.Удирдлага төлөвлөлт, хяналтын баг

- Эрсдэлийн үнэлгээ,
- Цар тахлын үеийн болон урьдчилан сэргийлэх төлөвлөлт
- Хүний нөөц
- Багуудын үйл ажиллагаанд хяналт тавих

2.9.Санхүү хангалтын баг

- Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт
- Хүнс, бараа материалын нөөц
- Ахуйн хэрэглээ хангамжийн нөөц

2.10.Мэдээлэл харилцаа холбоо-технологи, урьдчилсан сэргийлэх баг

- Мэдээллийн технологи
- Харилцаа холбоо
- Хэвлэл мэдээлэл, цахим орчны тандалт судалгаа, санал хүсэлт, хариу арга хэмжээ

2.11.Шуурхай штаб болон багууд бусад аймаг, нийслэлийн шуурхай штабтай үйл ажиллагаагаа уялдуулж мэдээ, мэдээлэл солилцож ажиллана

2.12.Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр иргэд, олон нийтэд нээлттэй ил тод байна

2.13.Шуурхай штабын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч хүн хүчийг бусад багт түр ажиллуулах, ажлын цагийн зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээг багуудын удирдлагуудын саналыг үндэслэн Шуурхай штабын дарга шийдвэрлэнэ.

**Гурав.Штабын дарга, орлогч, нарийн бичгийн эрх үүрэг**

**3.1.Шуурхай штабын дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.**

3.1.1.Засгийн газар Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах

3.1.2.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах

шинжилгээ хийх, тандалт хийх, бусад байгууллагуудыг мэдээллээр хангах дэд бүтцийг бий болгох санал боловсруулах

7.15.Аймгийн онцгой комисс, Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх

7.16.Мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд ойлгомжтой, товч, тодорхой бэлтгэж, нэг сувгаар хүргэх

7.17.Бэлтгэсэн мэдээ, мэдээллийн төслийг Шуурхай штабын орлогчид танилцуулж, үүрэг, чиглэл авах

7.18.Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд залруулга хийх

7.19.Олон нийтийн санаа бодлыг судалж, тандсаны үндсэн дээр мэдээ, мэдээллийг бэлтгэх, түгээх

7.20. Хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах.

### **Найм. Бусад зүйл**

8.1.Штабын бүрэлдэхүүн нь төрийн алба хаагчийн ёс зүйг баримтлан авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ:

8.2.Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллана.

8.3.Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн холбогдох байгууллагын удирдлага тухайн ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.4.Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.



3.

3.1.3. Шуурхай штаб, багуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавьж үүрэгжүүлэх, биелэлтийг тооцох

3.1.4. Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, аймгийн Онцгой комисс, бүсийн төвүүдтэй мэдээ, мэдээлэл солилцох, үйл ажиллагааг уялдуулах

3.1.5. Шуурхай штабын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх

3.1.6. Халдварын нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Онцгой комиссын даргаар батлуулж, биелэлтийг тайлагнах

3.1.7. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын Онцгой комисст үүрэг чиглэл өгөх, биелэлтийн хангуулах, хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах

3.1.8. Аймгийн онцгой комиссын дарга, гишүүдийг мэдээ, мэдээллээр хангах

3.1.9. Бусад

## **3.2. Шуурхай штабын орлогч дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.**

3.2.1. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

3.2.2. Шуурхай штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих

3.2.3. Халдварын нөхцөл байдалтай уялдуулан багуудын тавьсан санал, хүсэлт, арга хэмжээний саналыг Шуурхай штабын даргад танилцуулах

3.2.4. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтыг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах

3.2.5. Засаг даргын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийн төсөл боловсруулах, Шуурхай штабын тайланг олон нийтэд мэдээлэх

3.2.6. Шуурхай штабын бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, цаг ашиглалт, үүрэг гүйцэтгэлд хяналт тавих

3.2.7. Хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх, гарсан зөрчлийг арилгуулах, өргөдөл гомдлыг шийдвэрлэх

3.2.8. Нийслэл болон орон нутгийн Онцгой комиссын шуурхай штабуудтай хамтран ажиллаж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх

3.2.9. Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх ажилтныг томилгоожуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх





### **3.3. Нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

3.3.1.Аймгийн Онцгой комиссын хуралдааны зар хргэх, ирц бүртгэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, албажуулж бүртгэх

3.3.2.Шуурхай штаб, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги болон багуудын өдөр тутмын үйл ажиллагааны тайланг нэгтгэж орлогч даргад танилцуулах

3.3.3.Шуурхай штабын дарга, орлогч дарга нарыг хууль, эрх зүйн мэдээллээр хангах

### **3.4.Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж буй аймгийн Онцгой комиссын гишүүний үүрэг:**

3.4.1.Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх арга хэмжээг зохион байгуулах

3.4.2.Аймаг, сумаас орох, гарах албан томилолт, ар гэрийн гачигдал, оршуулгын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл олгож, бүртгэл хөтлөх

3.4.3.Иргэд, олон нийтийг цар тахлын нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээ, мэдээллээр хангаж, зөвлөгөө өгөх

3.4.4.Буяны ажилд оролцож буй иргэдийн бүртгэлийг гаргуулж авч байх талаар сумдын Онцгой комиссын дарга нарт өдөр тутам үүрэг чиглэл өгөх.

### **Дөрөв. Хариу арга хэмжээний багийн чиг үүрэг**

4.1.Хариу арга хэмжээний багийн ахлагч дараах үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх, тайлагнах, заавар зөвлөмж өгөх

4.1.2.Багийн тогтвортой ажиллагааг хангах, гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг сахиулах

4.1.3.Багийн гишүүдийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах

4.1.4.Багийн үйл ажиллагааны талаар Шуурхай штабын дарга, орлогчийг мэдээ мэдээллээр хангах

4.1.5.Штабын дарга болон орлогч даргын өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг хангах

4.1.6.Бусад багуудтай мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх

5.

4.1.7.Халдвар авсан иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангуулах

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлтийн чиглэлээр:**



4.1.8.Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах, тооцоо хийж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

4.1.9.Сэжигтэй болон батлагдсан тохиолдлоор нас барсан иргэнийг оршуулах бэлтгэлийг хангах, тээвэрлэх, хадгалах, оршуулах талаар орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагуудад чиглэл, зөвлөмж өгөх

4.1.10.Сэжигтэй, магадлалтай батлагдсан тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний өдөр тутмын мэдээллийг гаргах

4.1.11.Эхний болон давтан шинжилгээг авсан шуурхай арга хэмжээний багуудын үйл ажиллагаанд хяналт тавих

4.1.12.Шинжилгээний сорьцыг цаг хугацаанд нь лабораторид хүлээлгэн өгч байгаа мэдээллийг нэгтгэх

4.1.13.Лабораториудын хоорондын уялдаа холбоог хангах, шинжилгээний хариуг цаг хугацаанд нь гаргах үйл ажиллагаанд нь хяналт тавих

4.1.14.Суурин болон хөдөлгөөнт лабораторийн судалгаа, шаардагдах хэрэгсэл, ажиллах хүчний тооцоо гаргах, бэлэн байдлыг хангуулах, хяналт тавих

4.1.15.Халдвараас сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлт хийх объект, хүн хүч, тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа гаргах, халдваргүйжүүлэлт хийх ажлын зохион байгуулалтад хяналт тавих

4.1.16.Хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооцоо, нөөцийн судалгааг гаргах

4.1.17.Хүн амыг ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтад хамруулах судалгааг гаргаж хэрэгжүүлэх

4.1.18.Шинжилгээ өгөх шаардлагатай иргэдийг цагийн хуваарьтайгаар шинжилгээ өгөх боломжийг бүрдүүлэх, цэгийн байршил, цагийн хуваарийг мессежээр өгөх

**Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр:**

4.1.19.Цэргийн анги, хорих анги, ахмадын болон хүүхдийн асрамжийн газар зэрэг олон хүнтэй газар, ээлжээр ажилладаг аж ахуйн нэгж байгууллагуудад халдвар хамгааллын дэглэм сахиулах талаар заавар, зөвлөмж өгөх, теле хяналтын камераар хянах боломж нөхцөлийг бүрдүүлэх

4.1.20.Тусгаарлан ажиглах байрны судалгааг гаргах, бэлэн байдлыг хангуулах, бэлтгэх, зөвшөөрөгдсөн байранд иргэдийг хуваарилах, тээвэрлэх

6.

4.1.21.Эрсдэлтэй бүс нутгаас ирсэн олон ойрын хавьтлаар тусгаарлагдсан иргэдийн тоон болон дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэх, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, мэдээлэх

4.1.22.Тусгаарлагдсан иргэдийн мэдээллийг шалгах

4.1.23.Тусгаарлан ажиглах байранд байгаа шинжилгээнд хамрагдах иргэдийн судалгааг гаргах

4.1.24.Гэрийн ажиглалтад шилжих иргэдийн мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх

4.1.25.Цагдаа, Тагнуулын хэлтэстэй хамтран илрүүлсэн ойрын хавьтлыг тусгаарлах үйл ажиллагаанд нь хяналт тавих, зохицуулах

4.1.26.Иргэдийг тусгаарлан ажиглалтаас гаргах үйл явцад хяналт тавьж зохицуулах

4.1.27.Тусгаарлах байрнаас гарах иргэдийг гэрийн ажиглалтад гаргах зөвшөөрлийг тухай өдрийн 11 цагаас өмнө аймгийн шуурхай штабт хүргүүлэх ажлыг зохион байгуулах

4.1.28.Судалгаа, мэдээллийг нэгтгэж аймгийн шуурхай штабт хүргүүлэх

4.1.29.Эмч, эмнэлгийн мэргэжилтний нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай газарт томилуулах;

4.1.30.Архаг хууч өвчтэй, эмнэлгийн тусламж, үйлчилгээ нэн шаардлагатай хүмүүсийн судалгааг гаргах

4.1.31.Шаардлагатай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

4.1.32.Тусгаарлах байр, гэрийн ажиглалтад байгаа иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих

4.1.33.Тусгаарлан ажиглах байрны хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, гарсан зөрчлийг таслан зогсоох

4.1.34.Тусгаарлан ажиглах байр, гэр (амрах байр)-ийн эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмд хяналт тавих

4.1.35.Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах баг нь Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 20 дугаар тушаалаар баталсан “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Гэр (амрах байрт)-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

#### **Тархвар судлал, тандалтын чиглэлээр:**

4.1.36.Батлагдсан иргэдээс тархвар судлалын асуумж авч, их уурхайг тогтоох арга хэмжээг авах





7.

4.1.37.Халдвартай иргэдийн маршрут, зураглалыг гаргаж, ойрын болон дам хавьтлыг тогтоох

4.1.38.Илрүүлсэн хавьтлыг эрэмбэлэх, шаардлагатай хариу арга хэмжээг төлөвлөх

4.1.39.Хавьтлуудыг шинжилгээнд хамруулах, тусгаарлалтад авах иргэдийн судалгааг гаргаж, хариу арга хэмжээ, тусгаарлан ажиглалтын багт шилжүүлэх

4.1.40.Хариу арга хэмжээний болон тусгаарлан ажиглалтын багуудтай уялдаа холбоотой ажиллах

4.1.41.Батлагдсан тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах саналыг аймгийн Онцгой комисст хүргүүлэх

### **Хөдөлгөөний хязгаарлалт, хяналтын цэгийн үйл ажиллагаа**

4.1.42.Аймаг, сум, багуудын хөдөлгөөнийг хязгаарлах нарийвчилсан төлөвлөгөөг гаргах

4.1.43.Хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон бүс нутагт иргэд, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг шуурхай штабын зөвшөөрлөөр хөдөлгөөнд оролцуулж, хяналт тавих

4.1.44.Хяналтын цэг 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангах

4.1.45.Аймаг, сум, багуудын хөдөлгөөн хязгаарлах ерөнхий бүдүүвч зургийг гаргаж баталгаажуулах

4.1.46.Хөдөлгөөний хязгаарлалт тогтоогдсон бүс нутагт ажиллаж байгаа алба хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах

4.1.47.Хөдөлгөөн хязгаарлах хяналтын цэгт ажиллах албан байгууллагын хүч хэрэгслийн тооцоог гарган хуваарийг батлуулж, үйл ажиллагаанд хяналт тавих.

### **Тав. Удирдлага төлөвлөлт, хяналтын баг**

#### **Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр:**

5.1.Коронавируст халдварын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран хийх

5.2.Халдварын дотоодын тохиолдол, хавьтлын байршлын зураглалыг гаргах, түүнд үндэслэн хариу арга хэмжээг зохион байгуулах санал, зөвлөмж боловсруулах

5.3.Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, шаардлагатай нэмэлтийг тухай бүр оруулах



8.

5.4.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр болон Шуурхай штабын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, зөвлөмж, төлөвлөгөөний төсөл, танилцуулга зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулж, батлуулах



**Хүний нөөцийн чиглэлээр:**

5.5.Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг тооцох, ажиллах заавар, журмаар хангах, сургалтад хамруулах, хяналт тавих

5.6.Эмнэлэг, эмнэлгийн зориулалтаар ашиглах барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөц зэрэг бүх төрлийн нөөцийг дайчлах стратеги боловсруулах

5.7.Дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөлтийг хийх

**Багуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр:**

5.8.Багуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, зөрчлийг арилгуулах, заавар зөвлөмж өгөх

5.9.Штабын үйл ажиллагаа, тусгаарлах эмнэлэг, тусгаарлан ажиглах байрны бэлэн байдалд хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэм сахиулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих

5.10.Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт, бүх шатны онцгой комиссын шуурхай штаб, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын халдвар, хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг арилгуулах

5.11.Хяналт шалгалтын үр дүн, тайланг Шуурхай штабын даргад танилцуулах, заавар чиглэл авах

5.12.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тандалт, шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих

5.13.Эрсдэлтэй бүс нутгаас иргэдийг татан авах нэвтрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих

5.14.Шалган нэвтрүүлэх товчоо, хөдөлгөөний хязгаарлалтын үйл ажиллагаанд хяналт тавих

5.15.Хүнс, бараа, материал, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэлт, хангалтын байдал үнийн өсөлтөд хяналт тавих

5.16.Байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэм, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа, цахим бүртгэл хяналтын системийн нэвтрүүлэлтэд хяналт тавих.

**Цар тахлын үеийн болон урьдчилан сэргийлэх төлөвлөлтийн чиглэлээр:**



5.17.Салбар дундын нарийвчилсан төлөвлөгөө гаргах

5.18.Халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд хяналт тавих

### **6.Санхүү хангалтын баг**

**Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтын чиглэлээр;**

6.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээнд шаардагдах эм эмнэлгийн хэрэгсэл (урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл гэх мэт) хэрэгцээг тодорхойлох, нөөцийг бүрдүүлэх

6.2.Улсын хэмжээний хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг харгалзан стандарт шаардлагад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг төлөвлөх

**Хүнс бараа материалын нөөцийн чиглэлээр:**

6.3.Хүнсний нөөцийн судалгааг гаргах, тухай бүр тодотгох

6.4.Ар, тал, хангалтын (тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, ус, дулаан хувцас, байр, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал, хоол хүнсний хангамж, эмнэлгийн тусламж, санхүү) талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэх тодотгох

6.5.Гамшгаас хамгаалах албадын хүч хэрэгслийн нөөцийн судалгаа гаргах тодотгох

6.6.Эмзэг бүлгийн иргэдийн судалгааг гаргах, шаардлагатай тохиолдолд хүнсний тусламж, үзүүлэх төлөвлөлт, тооцоолол хийх, зохион байгуулах

**Ахуйн хэрэглээ хангамжийн нөөцийн чиглэлээр:**

6.7.Тусгаарлан ажиглах байр, эмнэлэг, хяналтын цэгүүдэд шаардагдах ахуйн хэрэглээний бараа материалын хэрэглээг тооцох.

### **7.Мэдээлэл харилцаа холбоо технологи, урьдчилан сэргийлэх баг**

**Мэдээллийн технологийн чиглэлээр:**

7.1.Цар тахалтай тэмцэх зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээллийн солилцоо, боловсруулалт, түгээлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх судалгаа хийх, санал боловсруулах

7.2.Шуурхай штабын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ, техник хангамж, интернэт болон тусгай сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, тэдгээрийн хэрэглэгчийн мэдээлэлд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх



7.3.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх зорилгоор хөгжүүлсэн мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах, мэдээллийг анхдагч эх үүсвэрээр авах, мэдээллийн нэгдсэн урсгалыг бий болгох, боловсруулах, оролцогч талуудыг нэгдсэн мэдээллээр хангах, нийтэд мэдээлэх зорилгоор салбар хоорондын уялдааг хангах

7.4.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн системүүдийн хооронд мэдээллийг шуурхай солилцох боломжийг судлах, санал боловсруулах

7.5.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх ажлын талаар мэдээлэл, халдварын статистик мэдээллийг нэгдсэн байдлаар мэдээлэх дэд бүтцийг бий болгох, E-Mongolia системээр дамжуулах хүргэх

7.6.Бүртгэл хяналтын программыг хөгжүүлэх

7.7.Арвайхээр сумаар дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгсэл, хот доторх иргэдийн хөдөлгөөнд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн камерын хяналтын системийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

7.8.Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах цахим хаяг, тусгай дугаарыг нээж, өргөдөл гомдлыг хүлээн авч хариуг тухай бүрт өгч байх

#### **Харилцаа, холбооны чиглэлээр:**

7.9.Шуурхай штабын 70322855, Эрүүл мэндийн газрын 70323536, Мэргэжлийн хяналтын 80663096 дугаарын утасны дуудлагын мэдээг өдөр бүр нэгтгэж, дүн шинжилгээ хийх

7.10.Тусгай дугаарт утас, нээлттэй утсанд ирсэн иргэдийн санал, гомдол, шүүмжлэлийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, штабын орлогч даргад танилцуулж, шийдвэрлүүлэх

7.11.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор “Цахим орчинд зохицуулалт хийх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллах

#### **Хэвлэл мэдээлэл, цахим орчны тандалт судалгаа, санал хүсэлтийн чиглэлээр:**

7.12.Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдлын талаарх орон зайн мэдээллийг бүрдүүлж, холбогдох мэдээллийн сангуудаас цахим хэлбэрээр татан төвлөрүүлж, дүн шинжилгээ хийх, үр дүн, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх

7.13.Халдварын нөхцөл байдлын талаарх мэдээллийг орон зайн мэдээллийн системүүдээр дамжуулан, иргэн, хуулийн этгээдэд хүргэх

7.14.Коронавируст халдвар (Ковид-19)-ын болон олон улсын хөл хориот бусад халдварт өвчний үед орон зайн мэдээллийн системийг ашиглан дүн

Аймгийн Засаг даргын 2021 оны.....<sup>03</sup>  
дугаар сарын 29-ны өдрийн 1/150 дүгээр  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Д.Одонбаяр (Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа)

Орлогч дарга: Б.Батбилэг (Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан  
сэргийлэх тасгийн дарга, Гамшгаас хамгаалах улсын  
хяналтын байцаагч дэд хурандаа)

Гишүүд: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)  
С.Ундрах (аймгийн Засаг даргын орлогч)  
Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)  
О.Ганбат (аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)  
Ж.Уламбаяр (Тагнуулын хэлтсийн дарга)  
С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн  
хяналтын газрын дарга)  
Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн  
газрын дарга)  
Б.Сүхбаатар (Зооноз өвчин судлалын төвийн дарга)  
Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)  
А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн дарга)  
М.Дэлгэрсайхан (Цэргийн штабын дарга, хурандаа)  
Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Гаваадамба (Онцгой байдлын газрын Эмч, сэтгэл  
зүйч ахмад)

Аймгийн Засаг даргын 2021 оны...<sup>03</sup>  
дугаар сарын 29-ны өдрийн 1/150 дүгээр  
захирамжийн гуравдугаар хавсралт



## САЛБАР ХООРОНДЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### 1.Хариу арга хэмжээний баг

Ахлагч: С.Ундрах (аймгийн Засаг даргын орлогч)  
Орлогч дарга: М.Дэлгэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Цэргийн штабын дарга, хурандаа)

#### 1.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүлэг

Ахлагч: Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл  
мэндийн газрын дарга)  
Гишүүд: Э.Хүдэрчулуун (БОЭТ-ийн захирал)  
Ю.Ичинноров (Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн  
хэлтсийн дарга)  
Б.Шүрэнцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн  
хяналтын газрын эмчилгээ, оношилгооны  
чанарын хяналтын улсын байцаагч)  
Б.Сүхбаатар (аймгийн Засаг даргын дэргэдэх Зооноз өвчин  
судлалын төвийн дарга)  
Л.Золзаяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн)  
А.Нямдаваа (аймгийн Мал эмнэлгийн газрын дарга)  
Г.Ганбаатар (Эрэн хайх, аврах салбарын дарга хошууч)  
П.Төрхишиг (Ариунсанаа эмнэлгийн гүйцэтгэх захирал)  
Ж.Бунджав (Өрхийн эмнэлгүүдийн холбооны тэргүүн)

#### 1.2.Тархвар судлал, тандалтын бүлэг

Ахлагч:М.Золзаяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
Тархвар судлаач)  
Э.Цэвэгмид (аймгийн Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан,  
дэд хурандаа)  
Ч.Ууганбаяр (аймгийн Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч)  
Д.Бат-Оргил (Цагдаагийн газрын дэд бөгөөд, эрүүгийн цагдаагийн  
тасгийн дарга цагдаагийн хошууч)  
Г.Надмидсүрэн(БОЭТ-ийн тархвар судлаач)  
Д.Сайнжаргал(БОЭТ-ийн тархвар судлаач)  
Ц.Сонинбаяр(аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
мэргэжилтэн)  
С.Энхцэцэг(аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
мэргэжилтэн)  
Л.Алтаншагай (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын  
газрын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын  
улсын байцаагч)  
Г.Балжинням (аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын  
хяналтын байцаагч ахмад)

Ч.Даваасүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгааллын мэргэжилтэн)



### 1.3.Тусгаарлах, гэрийн ажиглалтын бүлэг

Ахлагч: Г.Баясгалан(аймгийн Засаг даргын Байгагль орчин аялал жуулчлалын газрын дарга)  
Гэрийн ажиглалтын хэсэг: Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)  
Л.Мөнхболд (аймгийн Цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийн дарга)  
Б.Эрхэмбаатар(аймгийн Прокурорын газрын ерөнхий Прокурор, хууль цаазын шадар зөвлөх)  
Д.Амартүвшин(Автотээврийн төвийн дарга)  
С.Энхцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)  
С.Оюунбилэг (аймгийн Онцгой бйдлын газрын нягтлан бодогч, дэслэгч)  
Б.Ариунцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлэгийн хяналтын улсын байцаагч)  
Б.Лхагвачулуун (Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн оператор)  
Тусгаарлах байрны хэсэг:  
С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)  
С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)  
Х.Батпүрэв (аймгийн Цагдаагийн газрын нийтийн хэв журам, Хамгаалах тасгийн дарга цагдаагийн хошууч)  
Ж.Ганбаатар (аймгийн Онцгой байдлын газрын хөдөлмөр хамгаалал, техник тоног төхөөрөмж хариуцсан инженер, хошууч)  
С.Цэдмаа (Улсын бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон Дэмбэрэлсайхан (ЭБЦТС ТӨХК-ний захирал)  
Н.Ширчин (МЦХ-ний Өв дахь аймгийн салбарын захирал)


### 1.4.Хөдөлгөөний хязгаарлалт хяналтын цэгийн үйл ажиллагааны бүлэг

Ахлагч: О.Ганбат (аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)  
Б.Галбадрах (ЗХ-ний 256-р ангийн захирагч, хурандаа)  
Д.Лхам-Оролмаа (Өв-АЗЗА ТӨХК-ний гүйцэтгэх захирал)  
С.Эрдэнэсүрэн (Арвайхээр сумын Засаг даргын орлогч)  
Ж.Энхтөр (аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 12-р ангийн захирагч)  
Ч.Хүрэлбаатар (аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)  
Т.Ариунболд (аймгийн Засаг дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)  
Б.Анхтуяа (Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн дарга)

### 2.Удирдлага, төлөвлөлт, хяналтын баг

Ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)  
Б.Батсайхан (аймгийн Онцгой байдлын газрын хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа)

3.

- 
- Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)  
А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
Д.Лхагважав (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга)  
Р.Наранцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Ч.Адъяа (Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт сургалтын офицер, дэд хурандаа)  
Н.Оюунтуяа (Эрүүл мэндийн газрын удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга)  
Б.Сэргэлэнбаатар (аймгийн Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн дэслэгч)  
М.Ганцэцэг (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн)  
С.Ганчимэг (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга)  
Д.Мөнхнасан (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал)  
Т.Үржинпүрэв (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)  
А.Балжинням (аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас Хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахмад)  
Ч.Отгонжаргал (аймгийн Цагдаагийн газрын захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч)

### **3.Санхүү, хангалтын баг**

Ахлагч: Ц.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

- Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Ж.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газрын дарга)  
Ж.Оюунчимэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хэлтсийн дарга)  
О.Цэрэнчимэд (аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)  
Ц.Алдаржав (аймгийн Онцгой байдлын газрын ахлах нягтлан бодогч, хошууч)  
Б.Валя (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын ахлах нягтлан бодогч)  
Б.Энхцогт (аймгийн Улаан загалмайн хорооны дарга)  
Ц.Хоролсүрэн (Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ын дарга)  
М.Мөнхбат (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын эдийн засагч)

### **4.Мэдээлэл, харилцаа холбоо-технологи, урьдчилсан сэргийлэх баг**



4.

Ахлагч: Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)



- Я.Жаргал (аймгийн Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга)
- М.Жамъяншарав (Мэдээлэл, холбоо сүлжээ ТӨХК-ний Өв дахь салбарын дарга)
- Н.Гуамарал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)
- С.Пүрэвсүрэн (аймгийн Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх асуудал, сургалт суртчилгаа хариуцсан мэргэжилтэн ахмад)
- Б.Туяацэцэг (аймгийн Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч)
- Б.Оюунчимэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын сургалт суртчилгаа хариуцсан мэргэжилтэн)
- Б.Тайванбаатар (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
- П.Цэнгэлбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын олон нийттэй харилцах ажилтан)
- Н.Очирбат (аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн)
- Т.Нарангарав (аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч)
- Т.Чимэддорж (Өвөрхангай аймаг дахь сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн тэргүүн)

-оОо-